

ДААТГАЛЫН МЭДЭЭ

2011 оны 1 дүгээр сар

1. ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ЭЗЭМШИГЧДИЙН МЭДЭЭЛЭЛ:

2011 оны 1 дүгээр сарын байдлаар даатгалын салбарт үйл ажиллагаа явуулж буй тусгай зөвшөөрөл эзэмшигчид болон тусгай зөвшөөрөлд орсон өөрчлөлтүүд дараах байдалтай байна:

/тоогоор/					
№	Тусгай зөвшөөрөл эзэмшигчид, өөрчлөлт	2010-ХII	Нэмэгдсэн	Хасагдсан	2011-I
1	Даатгалын компани	17			17
2	Даатгалын компанийн салбар	138	1 ¹		139
3	Даатгалын төлөөлөгч	2061		399 ²	1662
4	Даатгалын зуучлагч	9			9
5	Даатгалын хохирол үнэлэгч	6	1 ³		7
6	Актуарч	12			12
7	Бусад		2 ⁴		

Тайлант үед даатгалын компани, даатгалын зуучлагч, актуарчийн тоонд өөрчлөлт ороогүй байна.

¹Хорооны даргын 2011 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн 18 дугаар тушаалаар “Соёмбо даатгал” /хуучин нэрээр “Түшиг даатгал”/ ХХК-д УБ хотын СБД-ийн нутаг дэвсгэрт салбар ажиллуулахыг зөвшөөрсөн;

²Хорооны 2011 оны 1 дүгээр сарын 13-ны өдрийн 3 дугаар тогтоолоор “Практикал даатгал” ХХК-ийн 3 даатгалын төлөөлөгчийн, 2011 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн 41 дүгээр тогтоолоор “Соёмбо даатгал” ХХК-ийн 8 даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон;

³Хорооны даргын 2011 оны 1 дүгээр сарын 11-ний өдрийн 3 дугаар тушаалаар “Практикал даатгал” ХХК, “Тэнгэр даатгал” /хуучин нэрээр “Прайм женерал даатгал”/ ХХК-ийн 142 даатгалын төлөөлөгчийн, 2011 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 14 дүгээр тушаалаар “Миг даатгал” ХХК, “Тэнгэр даатгал” ХХК, “Нэйшнл лайф даатгал” ХХК-ийн 145 даатгалын төлөөлөгчийн, 2011 оны 1 дүгээр сарын 27-ны өдрийн 16 дугаар тушаалаар “Соёмбо даатгал” ХХК-ийн 101 даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон;

⁴Хорооны 2011 оны 1 дүгээр сарын 13-ны өдрийн 2 дугаар тушаалаар “Хөрөнгө үнэлгээний төв” ХХК-д даатгалын хохирол үнэлэгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосон;

⁵Хорооны 2011 оны 1 дүгээр сарын 13-ны өдрийн 1 дүгээр тогтоолоор “Нэйшнл лайф даатгал” ХХК-ийн дүрмийн сангийн хэмжээг 1.0 тэрбум төгрөг байсныг 2.0 тэрбум төгрөг болгон нэмэгдүүлэхийг зөвшөөрсөн;

⁶Хорооны 2011 оны 1 дүгээр сарын 13-ны өдрийн 4 дүгээр тогтоолоор “Моннис даатгал” ХХК-ийн гүйцэтгэх захирлын албан тушаалд С.Ганбаатарыг томилохыг зөвшөөрсөн.

2. САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЭЛ:


Даатгалын байгууллагуудын 2011 оны 1 дүгээр сарын даатгалын үйл ажиллагааны үндсэн үзүүлэлтүүдийг 2010 оны 1 дүгээр сарынхтай харьцуулбал:

Ердийн даатгалын компаниудын хувьд :

№	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		2010-I	2011-I
1	Даатгалын нийт хураамж	910,215,852.0	2,492,946,653.7
2	Олгосон нийт нөхөн төлбөр	404,565,632.0	611,459,428.2
3	Давхар даатгалд төлсөн хураамж	53,027,158.0	299,942,614.1
4	Байгуулсан даатгалын гэрээний тоо /ширхэг/	5,787	7,635
5	Даатгалын гэрээнүүдээс хамгийн өндөр үнэлгээний дүн	200,000,000,000.0	125,764,000,000.0
6	Хамгийн их дүнтэй нөхөн төлбөрийн дүн	37,513,684.0	18,277,300.0

2011 оны 1 дүгээр сард даатгалын компаниудын төвлөрүүлсэн даатгалын нийт хураамжийн орлого нь өмнөх оны мөн үеийнхээс 1,582.7 сая төгрөгөөр, олгосон даатгалын нөхөн төлбөр 206.9 сая төгрөгөөр, давхар даатгалд төлсөн хураамж 246.9 сая төгрөгөөр тус тус өссөн байна.

Даатгалын компаниудын даатгалын хураамжийн орлого, нөхөн төлбөр, давхар даатгалд төлсөн хураамж, сая төгрөгөөр



Урт хугацааны даатгалын компанийн хувьд :

№	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		2010-I	2011-I
1	Даатгалын нийт хураамж	2,570,746.2	8,422,929.0
2	Олгосон нийт нөхөн төлбөр	410,000.0	5,560,898.0

3	Давхар даатгалд төлсөн хураамж		
4	Байгуулсан даатгалын гэрээний тоо	11	27
	Үүнээс: -Хувь хүний хугацаат даатгалд	6	2
	-Байгууллагын хугацаат даатгалд	1	2
	-Өндөр хамгаалалттай ЭМД-д	4	
	-Эмнэлгийн мөнгөний даатгалд		
	-Сургалтын төлбөрийн хуримтлалын даатгалд		13
	-Тэтгэврийн даатгалд		
	-Орон сууцны даатгалд		8
	-Хуримтлалын даатгалд		1
	-Зээлдэгчийн амь насны даатгалд		1
5	Даатгалын гэрээнүүдээс хамгийн өндөр үнэлгээний дүн	10,000,000.0	20,000,000.0
6	Хамгийн их дүнтэй нөхөн төлбөрийн дүн	360,000.0	440,000.0

“Нэйшнл лайф даатгал” ХХК-ийн 2011 оны 1 дүгээр сарын даатгалын хураамжийн орлого болон нөхөн төлбөрийг 2010 оны мөн үеийнхтэй харьцуулж үзэхэд даатгалын хураамжийн орлого 5.9 сая төгрөгөөр, нөхөн төлбөр 5.2 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

Даатгалын зуучлагч компаниудын хувьд :

№	Үзүүлэлт	/төгрөгөөр/		
		2010-XI	2010-XII	2011-I
1	Даатгуулагчаас шууд орж ирсэн даатгалын хураамж	29,574,894.9	29,395,964.7	17,536,876.2
2	Даатгалын зуучлагчийн орлого	21,524,396.0	17,037,806.3	13,180,745.4
3	Зуучилсан даатгалын гэрээний тоо	18	34	32
4	Зуучилсан даатгалын гэрээнүүдээс хамгийн өндөр үнэлгээний дүн	5,138,752,188.0	3,807,505,112.4	16,230,000,000.0

2011 оны 1 дүгээр сарын байдлаар даатгалын зуучлагч компаниуд 32 даатгалын гэрээг даатгагчдад зуучлан 13.2 сая төгрөгийн зуучлалын орлого олсон байна.

Даатгалын хохирол үнэлэгч компаниудын хувьд :

№	Үзүүлэлт	/төгрөгөөр/
		2011-I
1	Даатгалын хохирол үнэлсэний орлого	4,252,185.2
2	Үнэлсэн даатгалын хохирлын тоо	304
3	Үнэлсэн даатгалын хохирлоос хамгийн өндөр хохирлын дүн	28,870,000.0

2011 оны 1 дүгээр сарын байдлаар даатгалын хохирол үнэлэгч компаниуд 304 даатгалын хохирлыг үнэлж, 4.3 сая төгрөгийн даатгалын хохирол үнэлсний орлоготой ажиллажээ.